



## ӨСВӨР ҮЕИЙНХЭНД БЭЛГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ “SRHR” ЦАХИМ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

### **Зохион байгуулагч:**

Youth LEAD Mongolia (Залуусын манлайлал) ТББ

### **Сургалтын зорилго:**

SRHR нь өсвөр үеийнхэнд интерактив тоглоом, дасгалуудыг ашиглан бэлгийн боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүний эрхийн талаар мэдлэг олгож, манлайлал, харилцааны ур чадвараа хөгжүүлэхэд нь түлхэц болох зорилготой.

### **Хамрах хүрээ:**

Өсвөр үеийн хүүхэд залуучууд

### **Агуулга:**

1. Хичээлийн нээлт **5 минут**
2. Нөхөн үржихүйн эрүүл мэнд ба нөхөн үржихүйн эрх **20 минут**

Хүсээгүй жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх

Consent буюу зөвшөөрөл (Сурагчдад кейс жишээнүүд дээр тулгуурлан зөвшөөрөлтэй буюу consensual бэлгийн харилцааг тайлбарлах дасгал)

3. БЗДХ болон тэдгээрээс сэргийлэх арга замууд **10 минут**

Дасгал: Шош болон будаа (БЗДХ халдварлах үйл явц хэрхэн өрнөдөг болохыг шош болон будаагаар адилган сурагчдад энгийнээр ойлгуулж, урьдчилан сэргийлэх үр дүнтэй аргуудыг танилцуулах)

4. Асуулт, хариултын цаг **10 минут**

### **Цахим хичээл:**

YouTube платформоор орж 5 бичлэг үзээд асуулгад хариулж сертификат авна.

Линк: <https://cutt.ly/PMgEiEX>

## ӨСВӨР ҮЕИЙНХЭНД БЭЛГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ “SRHR” ЦАХИМ СУРГАЛТЫН МОДУЛЬ

### **Сургалтын зорилго:**

TeenGen нь өсвөр үеийнхэнд интерактив тоглоом, дасгалуудыг ашиглан бэлгийн боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүний эрхийн талаар мэдлэг олгож, манлайлал, харилцааны ур чадвараа хөгжүүлэхэд нь түлхэц болох зорилготой. **45 минут** үргэлжилнэ.

### **Агуулга:**

1. Хичээлийн нээлт **5 минут**
2. Нөхөн үржихүйн эрүүл мэнд ба нөхөн үржихүйн эрх **20 минут**

Ариун цэвэр (Хөвгүүдэд товч тайлбарлах)

Хүсээгүй жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх (Эрэгтэй талаас нь тайлбарлах)

Consent буюу зөвшөөрөл (Сурагчдад кейс жишээнүүд дээр тулгуурлан зөвшөөрөлтэй буюу consensual бэлгийн харилцааг тайлбарлах дасгал) - 49 хуудас 1.9.3

3. БЗДХ болон тэдгээрээс сэргийлэх арга замууд **10 минут**

Дасгал: Шош болон будаа (БЗДХ халдварлах үйл явц хэрхэн өрнөдөг болохыг шош болон будаагаар адилган сурагчдад энгийнээр ойлгуулж, урьдчилан сэргийлэх үр дүнтэй аргуудыг танилцуулах) - 73 хуудас 1.13

4. Genderbread person
5. Асуулт, хариултын цаг **10 минут**

Б-д Ану таалагддаг. Ануг гэртээ харих замд нь Б дагаж яваад хүнгүй газар байхад нь гүйцэж очоод, хөхөнд нь хүрэв. Ану үгүй гэж хэлсэн хэдий ч түүнийг гүйж зугтах хүртэл Б үйлдлээ зогсоосонгүй. (Б-гийн үйлдэл зөв үү буруу юу?) hurch bolohgui 3 tseg

### **Буруу Sexual assault Бэлгийн халдлага**

Охидын хувцас солих өрөөний үүдэнд хэсэг хөвгүүд зогсоод, боломж гарвал харах гээд, гарж ирэхэд нь өдөх гээд зогсож байв. (Тэдгээр хөвгүүдийн үйлдэл зөв үү буруу юу?)

### **Буруу Sexual harassment Бэлгийн дарамт**

Т Сарнай хоёр бие биедээ сайн. Т Сарнайгаас үнсэж болох уу гэж асуухад Сарнай болно оо гэсэн. (Т-гийн үйлдэл зөв үү буруу юу?)

### **Зөв**

Дорж Дулмаа хоёр гэрлэхээр төлөвлөсөн бөгөөд 2 талын гэр бүлүүд танилцаж уулзацгаав. Тэр орой нь Дорж Дулмаад: Хоёулаа гэрлэх нь тодорхой болсон учраас өнөөдөр секс хийе гэж хэлэв. Дулмаа үгүй гэв учир нь хуримын шөнө болтол хүлээх хүсэлтэй байв. Дорж: Надад хайртай л юм бол чи надтай дотно харьцаанд орохоос татгалзах ёсгүй биз дээ гэж ятгах гэж оролдов. (Доржийн үйлдэл зөв үү буруу юу?) **Буруу Sexual harassment Бэлгийн дарамт**

Цэцэгээ Мөнхөө хоёр бие биедээ сэтгэлээ илчлээд удаагүй байв. Цэцэгээ Мөнхөөгөөс үнсэж болох уу гэж асуухад Мөнхөө зөвшөөрсөнгүй. Цэцэгээ: Би чамайг үнсэж болохгүй юм бол чи өөрөө намайг үнс гэж шаардав. (Цэцэгээгийн үйлдэл зөв үү буруу юу?)

### **Буруу - хүчилж болохгүй**

Гэрэлхүү Гэрэлмаа хоёр гэрлэсэн хосууд. Нэгэн өдөр Гэрэлхүү бэлгийн харьцаанд орохыг хүсэв. Харин Гэрэлмаа хүссэнгүй. Гэрэлхүү Гэрэлмааг бэлгийн харилцаанд оруулах гэж хүчлэв. (Гэрэлхүүгийн үйлдэл зөв үү буруу юу?) (Henees ch bj bolno, oir dotnii, dotno hariltsaatai esvl tanihgu hun bj bolno)

### **Буруу - бэлгийн хүчирхийлэл.**

Бат Болд хоёр нэг ангийн хүүхдүүд. Хичээлийн дараа баавгайн чих тоглож байгаад Болдыг үүрнийхээ буланд зогсож байхад нь Бат хажууд нь ирээд бэлэг эрхтнийг нь базаж бариад юу ч хэлэлгүй тоглоомоо үргэлжлүүлэв. (Батын үйлдэл зөв үү буруу юу?)

### 73 хуудас 1.13 Будаа ба шош

1 алхам - А шилэн савыг дан будаагаар дүүргэнэ. Б шилэн саванд шошоо будаатай жигд хольж хийнэ. В шилэн савны ёроолд шошоо хийгээд будаагаар дүүргэнэ.

А - ХДХВ-гүй хүний биеийн шингэнийг төлөөлнө.

Б - ХДХВ-тэй хэрнээ ямар нэгэн эмчилгээнд ороогүй, вирус нь идэвхтэй хүний биеийн шингэнийг төлөөлнө.

В- ХДХВ-тэй бөгөөд зохих ёсоор нь эмчилгээгээ тасралтгүй хийлгэж байгаа хүний биеийн шингэнийг төлөөлнө.

2 алхам - А шилэн савыг тайлбарлана. Б шилэн савыг тайлбарлахдаа дээрээс нь шош нэмж, ХДХВ-ын халдвар авсныг харуулах. Б шилэн савыг тайлбарлахдаа өөр өвчин хавсрах эрсдэлтэйг сануулах.

3 алхам - В шилэн савыг тайлбарлахдаа эмчилгээ хийж байгаа тохиолдолд цус болон үрийн шингэн гэх мэт биеийн шингэнүүдэд вирусыг дарангуйлж байгааг хэлнэ.

4 алхам - Эмийг таслахгүй, цагтаа, өдөр болгон хэрэглэх.

5 алхам - 3 хүн дуудаж гаргаад 3 шилэн савнаас гараар нь дээж авахуулна. Тэгээд тайлбарлах.

6 алхам - Өөр сайн дурын сурагчийн гаран дээр салфетка тавина. Дээрээс Б савны шоштой будааг асгаж үзүүлнэ. Үүнээс бэлгэвч хэрхэн ХДХВ ба БЗДХ-аас сэргийлдэгийг энгийнээр тайлбарлана.

**ӨСВӨР ҮЕИЙНХЭНД БЭЛГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ**

## “SRHR” ЦАХИМ СУРГАЛТЫН АСУУЛГА

Нэр  
Нас  
Email  
Утас

Эдгээрээс аль замаар нь БЗДХ халддаг вэ

А Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох  
В Халдвартай цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэх  
Е Халдвартай эхээс урагт халдах  
F Халдвартай зүү тариур хэрэглэх  
Жи Дээрх бүгд

ХДХВ халдварладаг биеийн шингэнүүдэд аль нь орохгүй вэ

А цус  
В шүлс  
С дурын шингэн  
D үрийн шингэн

ХДХВ гэж юу вэ

Хүний дархлал хомсдолын вирус  
Хүний дархлал хомсдолын вакцин  
Хамгийн дархлал хомсдох вирус  
Хэсэг дархлаа хомсдох вирус

Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ) авсан үедээ өөрийгөө эмчлэх гэж оролдох нь ямар үр дагавартай байдаг вэ

.....

Бэлгийн дарамт ихэнхдээ санаатай хийсэн үйлдэл байдаг  
Тийм  
Үгүй

Сургалтын бичлэг дэх жишээн дээр ангийнхаа хүүхдийн бэлэг эрхтэнд зөвшөөрөлгүй хүрсэн нь ямар үйлдэлд тооцогдох вэ

Бэлгийн дарамт  
Бэлгийн халдлага  
Бэлгийн хавьтал  
Бэлгийн хүчирхийлэл

+18 агуулга бүхий онигоо ярьж тухгүй мэдрэмж төрүүлэх нь эдгээрийн аль нь вэ

Бэлгийн дарамт

Бэлгийн халдлага

Бэлгийн хавьтал

Бэлгийн хүчирхийлэл

Гэрэлсэн хосуудын хооронд бэлгийн хүчирхийлэл тохиолддоггүй

Үнэн

Худал

Бэлгийн дарамтад өртсөн тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ

.....

Энэхүү сургалтын талаар хаанаас олж мэдсэн бэ

Social media (Facebook/Instagram)

Youthlead.mn website

YouTube

Найз/Ангийн хүүхэд

Сургууль/Багш

Бусад